

## МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ХӨГЖИЛ БОЛОН ХҮН АМЫН ОРЛОГОД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

*Г.Мөнхнасан (Ph.D), дэд профессор, Маркетинг олон улсын худалдааны тэнхим, Эдийн Засгийн Сургууль, Монгол улсын Их Сургууль*

*Д.Нарандалай, магистр, Маркетинг олон улсын худалдааны тэнхим, Эдийн Засгийн Сургууль, Монгол улсын Их Сургууль*

### Хураангуй

Энэхүү судалгаа нь Монголын байгалийн баялгийн олборлолтын эрчимтэй хөгжил нь Монголын хүн амын орлого, цалин хөлсөнд хэрхэн нөлөөлж байгааг судлахад чиглэсэн. Манай эдийн засгийн хөгжлийн үр дүнд уул уурхайн салбарын гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, орлого өсч байгаагаас уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хөлс нэмэгдэж, энэ нь бусад салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Уул уурхайгаас орж ирэх орлого нэмэгдсэнээр эдийн засаг дахь цалин болон үнийн түвшин өсч байгаа бөгөөд энэ нь манай улсын өрсөлдөх чадварыг сулруулж байна. Мөн уул уурхайн салбар эдийн засагт байгаа капитал болон хөдөлмөрийн хүчин зүйлсийг татснаар нэг салбарын хэт давамгайлал бий болж Голланд өвчний эрсдлийг нэмэгдүүлж байна.

Байгалийн баялгийн салбарын өсөлтийн сөрөг үр дагаварт эдийн засгийн хүчин зүйлсээс гадна улс төрийн шийдлүүд нөлөөлдөг. Тиймээс энэ орлогыг зөв удирдах “судалгаанд тулгуурласан”, “оновчтой”, “монголд менежмент”-ийг бий болгох шаардлагатай байна. Тухайлбал, сул хөгжсөн дэд бүтэц, хүнд болон хөнгөн аж үйлдвэрийн салбарууд, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх замаар эдийн засгийн бусад салбарт ажлын байрыг бий болгож, тэдгээр салбарын ДНБ-д эзлэх хувийг өсгөхөд “баялгийн санг ашиглах” нь зүйтэй байна.

**Түлхүүр үгс:** Уул уурхайн хөгжил, хүний хөгжил, нийгмийн хамгаалал, Голланд өвчин, эх орны хишиг, хүн амын орлого, цалингийн өсөлт, ажил эрхлэлт

### 1. Оршил

Дэлхийн зах зээл дээр өсөн нэмэгдэж буй байгалийн баялгийн эрэлтийг даган байгалийн баялгийн үнэ өсч, байгалийн их хэмжээний баялгийг эзэмшигч орон болох Монгол Улсын эдийн засагт таатай байдлыг бий болгож байна. Байгалийн баялгийг олборлолтоос үүдэлтэй эдийн засгийн таатай байдал бий болоход 2 төрлийн үр дүн гарч ирдэг бөгөөд нэг нь нөөцийн шилжилтийн үр нөлөө (resource movement effect) нөгөө нь зардлын үр нөлөө (spending effect) юм. Нөөцийн шилжилтийн үр нөлөө гэдэг нь эдийн засгийн таатай байдал үүсэхэд таатай байдал үүссэн салбарт таатай байдал үүсээгүй салбарын үйлдвэрлэлийн элементүүд шилжин орж ирдэг үзэгдэл бөгөөд, зардлын үр нөлөө гэдэг нь эдийн засгийн таатай байдлаас шалтгаалан бодит орлого өсч таатай бус

салбарын эрэлт нэмэгдэж үнийн өсөлт, валютын ханш өсөх зэрэг үзэгдэл бий болдог. Үүнийг “Голланд өвчин” буюу “байгалийн баялгийн хараал” тусч байгаа гэж олон улсын эдийн засагт тайлбарладаг.

Өөрөөр хэлбэл уул уурхайн салбар нь үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг бусад салбараас татаж авдаг. Тухайлбал өндөр боловсролтой боловсон хүчин уул уурхайн салбар луу шилжих хөдөлгөөн хүчтэй явагдаж бусад салбар нь чадвартай боловсон хүчний дутагдалд орон үйлдвэрлэлийн бүтээмж буурдаг. Баялгийн олборлолттой холбоотой хөгжлийн үр дүнд уул уурхай, олборлолтын салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, орлого өсөх бөгөөд үүнийг даган уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хөлс нэмэгдэж, бусад салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж хямрал үүсгэх үндсэн нөхцөл болдог нь Голланд

өвчний эрсдлийг нэмэгдүүлдэг. Тиймээс бидний хувьд Голланд өвчний талаар санаа зовохоос өөр аргагүй байгаа.

### Судалгааны зорилго, арга зүй

Монголын байгалийн баялгийн олборлолтын хөгжлийн өнөөгийн байдал, уул уурхайн хөгжил нь Монголын хүн амын орлого, цалин хөлсөнд хэрхэн нөлөөлж байгааг судлан үзэхэд чиглэсэн болно.

Судалгааны зорилгод хүрэхийн тулд Монголын уул уурхайн салбарын хөгжлийн өнөөгийн байдлыг ДНБ-д эзлэх хувийн өөрчлөлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортын бүтээгдэхүүний өсөлт зэрэг үзүүлэлтээр судаллаа. Мөн Монголын уул уурхайн салбарын эрчимтэй хөгжил орлогын хуваарилалтанд тухайлбал үйлдвэрлэлийн салбаруудын цалингийн өсөлт бууралт, хүн амын орлогод хэрхэн нөлөөлж байгааг судласан. Үүнийг тулд цалингийн өсөлтийг үйлдвэрлэлийн салбараар нь болон аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэрээр нь судалж, Хүний хөгжил сан"-гийн бодлого ба түүний хэрэгжилтийг авч үзсэн болно.

## 2. Монголын уул уурхайн салбарын хөгжлийн өнөөгийн байдал

Монгол улсын өрсөлдөх чадвар нь олон улсын хэмжээнд дундаас доогуур үзүүлэлттэй буюу 140 гаруй улсаас 93-д явж байна<sup>2</sup>. Гэхдээ энэ үзүүлэлт нь 2009-2010 онтой харьцуулахад 24 байраар ахисан байгаа нь Монгол улсын өрсөлдөх чадвар нэмэгдэж байгааг харуулж байна. Олон улс орны жишээнээс үзэхэд олборлох үйлдвэрлэлийн салбарын экспортын орлогын өсөлтийг дагалдан зах зээл дэх валютын нийлүүлэлт өсч, үндэсний валютын ханшийг чангаруулж өрсөлдөх чадвар нь сулрах талтай байдаг. Гэхдээ түргэн хурдацтай өсч буй эдийн засаг бүхий Монгол улс гадаадын үйлдвэрлэгчдийн сонирхлыг ихээр татаж, дотоодын зах зээл дэх өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна. Цаашид Монголын эдийн засгийн өсөлт нь 15-20% болох хандлагатай гэж эдийн засагчид таамаглаж байгаа бөгөөд энэ өндөр өсөлт нь Оюутолгойн үйлдвэрлэл эхлэхтэй холбоотой юм.

2 World Economic Forum, Global Competitiveness index, 2012-2013

## 2.1. Уул уурхайн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Монгол нь дэлхийд эхний 10-т орох байгалийн баялгийг эзэмшигч улс бөгөөд одоогийн хийгдээд байгаа судалгаагаар 80 гаруй төрлийн ашигт малтмалыг эзэмшиж дэлхийн нөөцийн зах зээл дээр олон улсын анхаарлыг татаж байна. Тэдгээр ашигт малтмалын дундаас нүүрс, зэс, молибден, алт, жонш, газрын тос зэрэг нь гол стратегийн ашигт малтмал юм. Үүнээс ашигт малтмалын нөөцөөрөө дэлхийн хэмжээнд жонш нь 3-рт, зэс нь 13-рт, нүүрс 10-т, молибден нь 11-рт, уран 14-рт бичигдэж байна. Мөн вольфрам, цайр, уран зэрэг чухал ашигт малтмалын нөөцтэй болох нь батлагдаад байна. 2010 оны судлагдсан байдлаар нүүрс 162,3 тэрбум тонн, зэс 540 сая тонн, молибден 540 сая тонн, алт 3000 тонн, жонш 590 тэрбум тонн, хүдэр 2,4 тэрбум тонн, цайр 100 сая тонн, газрын тос 5 тэрбум баррель, уран 61600 тонн байгаа гэж таамаглаж байна<sup>3</sup>. Үүнээс гадна тогтоогдоогүй ашигт малтмалын нөөц их байгаа гэж үздэг. Одоогийн байдлаар стратегийн нийт 15 орд байгаа бөгөөд Эрдэнэт, Төмөртэй, Нарийн сухайт, Бороо, Багануур, Шивээ овоо зэрэг ордуудад уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байна.

2003 оны үеэс эхлэн дэлхийн эрчим хүчний түүхий эдийн үнэ өссөн. Тухайлбал дэлхийн түүхий нефтийн үнийн өсөлт нь дунджаар 2004 онд 30 ам.доллар, 2005 онд 50 ам.доллар, 2006 онд 70 доллар, 2007 онд 69,68 ам.долларын үнийг барьж байсан. Үүний дараа 2008 оны 7 сарын эхэнд түүхэнд хамгийн өндөр үнэд<sup>4</sup> хүрсэн байна. Мөн уран, чулуун нүүрс, төмрийн хүдэр, өнгөт металл, хүрэл, цайр зэрэг эрчим хүчний ашигт малтмалын үнэ дэлхийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдлаас шалтгаалан 2006 он гэхэд 2%-5,6% өссөн байна<sup>5</sup>.

3 Чу Мён Чол, Ким Жи Ёнь, Түмэн голын төсөл ба олон улсын хамтын ажиллагааны чиглэл, Солонгосын олон улсын эдийн засгийн бодлогын хурээлэн, 2010.10:7

4 Дубайн үнэ нь 2008.7.4-нд 140,70/В хамгийн өндөр үнийг, WTI-ий үнэ нь 2008.7.14-нд 145,49/В хамгийн өндөр үнэ болж тэмдэглэгджээ. Ший, 국제자원정세와물·한자원개발협력, 2009

5 Ший, 국제자원정세와물·한자원개발협력, 2009

Монголын хувьд уул уурхайн үйлдвэрлэлийн салбарт гол хувийг зэс эзэлж байдаг. Тэгвэл дэлхийн зах зээлийн зэсийн нөөц ба зэсийн нийлүүлэлтийн хомсдолоос шалтгаалж зэсийн үнэ нь 2007 онд 40% өссөн байна. 2007 онд дэлхийн эрэлт 6,3% нэмэгдсэн бөгөөд энэ нь дэлхийн зах зээлийн 1/3-ийг эзэлж буй Хятадын зэсийн эрэлтийн өсөлтөөс шалтгаалсан юм. Дэлхийн түүхий эд, эрчим хүчний нийлүүлэлтийн хомсдолтой яг энэ үед Монголын чулуун нүүрс болон бусад ашигт малтмалын ихээхэн хэмжээний нөөц болон Өмнөговь аймагт зэс, алтны томоохон нөөц илэрсэн нь гадаадын орнуудын анхаарлыг маш их татах болсон. Дэлхийн нөөцийн зах зээлийн үнийн өсөлтөнд монгол улсын өмнөд хөрш Хятадын

эрчимтэй эдийн засгийн өсөлт ихээр нөлөөлсөн байна. Энэ нь дэлхийн хэмжээнд томоохон нөөцийг эзэмшигч улс болох Монголын ашигт малтмалын үйлдвэрлэлийн салбарыг эрчимтэй хөгжихөд нөлөөлсөн гэж үзэж болно.

Дэлхийн зах зээлийн байгалийн нөөцийн эрэлтийн өсөлтөөс шалтгаалан сүүлийн жилүүдэд Монголынуул уурхайн салбарын өсөлт нь хурдацтай явагдаж байгаа бөгөөд ДНБ-д эзлэх хувь нь жилээс жилд өсч байна. Тухайлбал, ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь нь 2006 онд 30%, 2007 онд 27,9%, 2008 онд 20,6%, 2009 онд 19,8%, 2010 онд 23,6%, 2011 онд 21,7% гарсан байна (Хүснэгт 1).

### Хүснэгт 1. Монголын ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь

Он	Мөнгөн дүн (сая.төгрөг)	Өсөлт (%)	ДНБ-д эзлэх хувь
2006	952 985,7	2,7	30,0
2007	1 340 854,4	1,1	27,9
2008	1 324 247,7	-1,6	20,6
2009	1 285 899,7	5,8	19,8
2010	1 913 040,1	3,6	23,6
2011	2 191 239,1	8,7	21,7

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011, pp. 139, 140, 141; 2007, pp. 123, 125, 126

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл нь жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2008 оноос бусад жилүүдэд байнгын өсөлттэй гарсан байна. 2008 онд дэлхийн эдийн засгийн хямрал болсонтой холбоотой дэлхийн нөөцийн зах зээл дээр ашигт малтмалын эрэлт буурснаас үйлдвэрлэлийн хэмжээ буурсан юм. Үүнээс хойшхи жилүүдэд уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимтэй нэмэгдсэн бөгөөд 2009 онд 5,8%, 2010 онд 3,6%, 2011 онд 8,7% өссөн байна.

Уул уурхайн салбарт үйлдвэрлэсэн уул уурхайн гол бүтээгдэхүүн нь нүүрс, газрын тос, зэсийн баяжмал, молибдений баяжмал,

алт, хайлуур жонш болон баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, гянтболд зэрэг уул уурхайн түүхий эд байна.

Хүснэгт 2-оос харахад сүүлийн жилүүдэд нүүрсний үйлдвэрлэл байнга нэмэгдэж байсан бөгөөд 5 жилийн дундаж өсөлт нь 33,7% байсан бөгөөд 2010 онд хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 74,2% өссөн байна. Энэ нь хятадын эрэлттэй шууд холбоотой юм. Газрын тосны үйлдвэрлэлийн хувьд 2007 онд өмнөх оноос 131,9% огцом өсөлттэй гарсан бөгөөд түүнээс хойшхи жилүүдэд ч үйлдвэрлэлийн хэмжээ өссөн байна.

**Хүснэгт 2. Уул уурхайн гол бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлт, (%)**

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2007	2008	2009	2010	2011	дундаж
Нүүрс	мянган тонн	14,4	9,0	43,4	74,2	27,3	33,7
Газрын тос	мянган баррел	131,8	38,1	59,3	16,7	16,8	53,5
Зэсийн баяжмал	мянган тонн	0,4	-2,6	2,4	-3,7	-2,7	-1,2
Молибдены баяжмал	тонн	40,9	-4,0	26,8	-8,7	-11,0	8,8
Алт	кг	-22,6	-13,1	-35,4	-38,4	-5,5	-23,0
Хайлуур жонш	мянган тонн	363,6	-14,4	15,2	15,6	-9,4	74,1
Хайлуур жоншны баяжмал	мянган тонн	-74,7	8,4	-19,3	22,0	-17,3	-16,2
Төмрийн хүдэр	мянган тонн	47,3	423,3	-0,6	132,3	77,3	135,9
Цайрын баяжмал	тонн	40,8	-7,2	-1,5	-20,4	-7,0	0,9
Гянтболд	тонн	n/a	-42,0	-72,8	-48,4	-36,7	-40,0

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011, хуудас 243; 2007, хуудас 217-ийг үндэслэн судлаач боловсруулав.

Төмрийн хүдрийн үйлдвэрлэл сүүлийн 2 жилд огцом өсөлттэй тухайлбал 2010 онд 132,3%, 2011 онд 77,3% өссөн бөгөөд сүүлийн 5 жилд 135,9% өсчээ.

Харин зэсийн баяжмал, алт, хайлуур жонш болон хайлуур жоншны баяжмал, цайрын баяжмал, гянтболдын үйлдвэрлэл нь сүүлийн 2-3 жилд буурсан байна.

Эндээс дүгнэж үзэхэд уул уурхайн салбарын зэсийн баяжмал, алт, хайлуур жонш болон хайлуур жоншны баяжмал, цайрын баяжмал, гянтболдын үйлдвэрлэл нь буурч, харин нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн үйлдвэрлэл огцом нэмэгдсэн байна.

**2.2. Уул уурхайн салбарын экспорт**

Манай улс нь гадаад худалдааны нээлттэй бодлогыг хэрэгжүүлж ирсэн бөгөөд Монголын эдийн засгийн гадаад худалдаанаас хараат байдлыг үзвэл 2000 онд 120%-тай гэж тэмдэглэгдсэн бол түүнээс хойш 100%-тай байна<sup>6</sup>. Зарим улсын туршлагаас үзвэл, тухайлбал Солонгос болон Хятад улсад зах зээлийн

нээлттэй тогтолцоог хэрэгжүүлж буй эдийн засгийн хөгжлийн эхэн үед гадаад худалдаанаас хамаарах хамаарал нь өндөр байх нь энгийн үзэгдэл бөгөөд<sup>7</sup> эдийн засаг нь хөгжих тусам ДНБ нэмэгдэж, дотоод зах зээл өргөжин гадаад худалдааны хамаарал нь багасан буурдаг байна.

Манай улсын одоогийн бодит байдалд хүн ам хэт цөөн, орлого бага байгаа учир дотоод зах зээлийн хэмжээ хэт бага байна. Мөн гадаад худалдааны тэнцэл нь байнгын алдагдалтай гарч, гадаад худалдаа нь хоёр хөршөөсөө ихээхэн хамааралтай байна. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн болон Хятадын эрчим хүчний нөөцийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа нөхцөл байдал нь байгалийн баялаг ихтэй манай улсын гадаад худалдаанд таатай нөхцлийг бүрдүүлж байна. Гэвч энэ нь Монголын экспортын өрөөсгөл бүтцийг улам муутгаж, сөргөөр нөлөөлөн уул уурхайн салбарт тулгуурлах байдал нэмэгдэж байна. 2011 оны байдлаар экспортод уул уурхайн салбарын бүтээгдэхүүн 90 шахам хувийг нь эзлэх болсон байна.

6 Ким Хонг Жин\*, С.Бурмаа “Монголын экспорт, импортын тогтолцооны шинжилгээ ба гадаад худалдааны бодлогыг шинэчлэлтийн хөтөлбөр”, 2010

7 Black, S. W., “Obstacles to Faster Growth in Transition Economies: The Mongolian Case,” IMF Working Paper, March, 2001

**Хүснэгт 3. Монголын экспортын бүтээгдэхүүний бүтэц, (%)**

Экспортын бүтээгдэхүүн	2007	2008	2009	2010	2011
Дүн	100,0	100,0	100,0	100,0	100,0
Малын гаралтай	1,4	1,3	2,4	2,4	0,8
Ургамлын гаралтай	0,1	0,0	0,3	0,0	0,1
Хүнс	0,1	0,1	0,3	0,2	0,2
Эрдэс бүтээгдэхүүн	66,8	60,3	66,4	81,0	89,2
Түүхий эд арьс шир	2,1	1,6	1,5	1,1	1,1
Нэхмэл бүтээгдэхүүн	13,5	8,9	10,2	7,4	5,0
Үнэт, хагас үнэт чулуу, металл	12,1	23,7	16,4	6,1	2,3
Бусад	3,9	4,1	2,5	1,8	1,3

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011-ийг үндэслэн судлаач боловсруулав.

Гадаад худалдаан дахь экспортын бүтцийг сүүлийн 5 жилийн байдлаар судалж үзвэл 2007 онд эрдэс бүтээгдэхүүн 66,8%-ийг эзэлж байсан бол 2011 онд 89,2%-ийг нь эзэлж байна. Экспортод гардаг байсан нэхмэл бүтээгдэхүүний хэмжээ 5 жилийн өмнөхөөс 8,5% буурч 2011 онд дөнгөж 5% болсон байна. Эрдэс бүтээгдэхүүн, түүхий эд, арьс шир, үнэт чулуу, металл, малын дайвар бүтээгдэхүүн, мах зэрэг түүхий эд хэлбэрээрээ гарч байгаа бүтээгдэхүүний хэмжээ 2011 онд 94 шахам хувь болсон байна.

Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспортын байдлыг судалж үзвэл сүүлийн 5

жилийн дунджаар нүүрсний экспорт 59,6% өссөн байна. Нүүрсний экспорт нь 2010 онд хамгийн их хувиар буюу 135,1% өссөн бөгөөд экспортод гарч байгаа нүүрсийг зөвхөн Хятад улс руу гаргасан байна. 2011 онд нүүрсний экспорт 21296.0 мянган тонн болж өмнөх онохоос 4569.8 мянган тонноор буюу 27,3% өссөн байна.

Газрын тосны хувьд Монгол Улсын олборлолт, хайгуулын салбарт<sup>8</sup> Хятад улс 99%-ийг эзэлдэг бөгөөд олборлосон газрын тосыг түүхийгээр нь өөрийн улс руу импортолдог. Газрын тосны экспортын хэмжээ сүүлийн 5 жилийн дунджаар 56,8% өссөн байна.

**Хүснэгт 4. Монголын уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспортын өсөлт, (%)**

Экспортын бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2007	2008	2009	2010	2011	дундаж
Нүүрс	Мянган тонн	37,3	26,6	71,8	135,1	27,3	59,6
Газрын тос	Мянган баррел	140,4	29,9	83,8	6,8	23,3	56,8
Зэсийн баяжмал	Мянган тонн	1,4	-4,1	0,7	-3,1	1,3	-0,8
Молибдены баяжмал	Мянган тонн	-3,0	28,1	63,4	-28,4	-12,5	9,5
Төмрийн хүдэр	Мянган тонн	33,3	-18,8	-11,5	21,7	-14,3	2,1
Алт	Тонн	-24,7	90,5	-50,7	-53,2	-49,0	-17,4
Хайлуур жоншны баяжмал	Мянган тонн	1,4	-3,1	-10,0	29,2	0,4	3,6
Цайрын баяжмал	Тонн	МБ	3,7	9,6	-20,5	1,2	-1,2

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн Хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011, хуудас 280; 2007, хуудас 244-ийг үндэслэн судлаач боловсруулав.

Нүүрс болон газрын тосны экспорт хамгийн ихээр нэмэгдэж байгаа бөгөөд бусад ашигт малтмалын хэмжээ багасах хандлагатай байна. Тухайлбал зэсийн баяжмалын болон цайрын баяжмалын экспорт 2010 онд буурч 2011 онд нэмэгдсэн

байна. Молибдены баяжмалын болон алтны экспорт сүүлийн 2 жилд нилээд буурсан хандлагатай байна.

<sup>8</sup> Эрдэс Баялаг Эрчим Хүчний Яам Хэвлэл Мэдээллийн Алба, Монгол улсын газрын тосны салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт, 2010



### 2.3. Уул уурхайн салбарт дахь гадаадын хөрөнгө оруулалт

Монголын уул уурхайн салбарын хөгжил эрчимтэй явж байгаагаас уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт ч мөн эрчимтэй нэмэгдэж байна. Монгол улсын уул уурхайн салбарт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын байдлыг сүүлийн 5 жилээр харвал тасралтгүй бөгөөд маш хурдацтайгаар өссөн байна. Энэ нь олон улсын зах зээл дээр алт, зэсний үнэ өсөлттэй байгаа, мөн Хятадын зах зээл дээр түүхий эдийн эрэлт болон үнэ байнга өсч байгаа, тухайлбал нүүрсний эрэлт өссөн нь Монголын уул уурхайн салбарт гадаадын компаниуд орж ирэх сонирхлыг илүү татах болсонтой

холбоотой юм.

1990-2011 оны хооронд Монголын уул уурхайн салбарт нийт 40 гаруй улсаас 7,241,934.9 мянган ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн нь монгол дахь нийт гадаадын хөрөнгө оруулалтын 73,3%-ийг эзэлж байна<sup>9</sup>.

Уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт нь 2008 онд өмнөх оноос 34,4%, 2009 онд өмнөх оноос 25,4%, 2010 онд өмнөх оноос 45,4% өсч тогтвортой бөгөөд хурдацтай өсөлтийг харуулж байна гэж дүгнэж болно. Улмаар 2011 онд огцом нэмэгдэж өмнөх оноос 316,4% өссөн нь Оюутолгойн хөрөнгө оруулалттай холбоотой байна.

**Хүснэгт 5. Монголын уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын өсөлт (мян.ам.доллар)**

Он	Дүн	Өсөлт (%)
2006	219018.56	8,41
2007	400272.86	82,8
2008	537805.77	34,4
2009	674438.41	25,4
2010	980646.52	45,4
2011	4083218.51	316,4

Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалтын газар, 2011

Хөрөнгө оруулалтыг тэргүүлж байгаа улс нь Хятад, Канад улсууд юм. Энэ нь 2003 оноос хойш олон улсын зах зээл дээр зарим ашигт малтмалын үнэ өссөнөөс Монгол улсын ашигт малтмалын нөөц нь, дэлхийн томоохон хөрөнгө оруулагч болох Хятад, Канад улсын сонирхлыг илүү татах болсонтой холбоотой. Мөн Хятад улсын хувьд дотоодын эрчим хүчнийэрчимтэй өсөлттэй холбоотойгоор үйлдвэрлэлд шаардлагатай ашигт малтмалыг хамгийн ойроос хямдаар авах боломжийг ашиглах Хятадын засгийн газрын бодлоготой холбоотой юм.

Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ уул уурхайн салбарт нэмэгдэж байгаа нь уг салбарт ажлын байрыг нэмэгдүүлж, энэ салбарт ажиллагсдын цалинг өсгөн хүн амын орлогыг нэмэгдүүлнэ.

### 3. Хүн амын орлогод гарсан гол өөрчлөлтүүд

#### 3.1. Цалингийн өсөлт

Манай улсад уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа нь уул уурхайн салбар болон бусад салбарт ажиллагсдын цалинд нөлөөлж байна. 2012 оны байдлаар Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй нийт иргэдийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг цагт 835 төгрөг 71 мөнгө, сард 140400 төгрөгөөр тогтоогоод байна. Монгол улсад ажил эрхлэгчдэд олгож байгаа цалингийн дундаж хэмжээ нь 2011 онд 424.2 мянган төгрөг байгаа бөгөөд 2010 оны цалингаас 24,2% өссөн байна.

<sup>9</sup> МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гадаадын хөрөнгө оруулалтын газар, 2011 оны статистик

2011 оны байдлаар үзвэл цалингийн дундаж үзүүлэлт хамгийн өндөр байгаа салбар нь уул уурхайн салбар бөгөөд дунджаар 732,4 мянган төгрөгийн цалин, хамгийн бага цалинтай салбар нь хөдөө аж ахуйн салбар бөгөөд дунджаар 203,1 мянган төгрөгийн цалин авч байна. Мөн 2011 онд уул уурхайн салбар болон барилгын салбарт ажиллагсдын цалин хамгийн

ихээр өссөн харин боловсрол, эрүүл мэнд, үйлчилгээний салбарт ажиллагсдын цалингийн өсөлт хамгийн бага байна (Хүснэгт 6). Цаашид ДНБ-ний хэмжээ өсөхтэй холбоотойгоор ажиллагсдын цалин өсөх нь тодорхой гэж судлаачид үзэж байна. Цалингийн өсөлтийг өмнөх жилтэй нь харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

#### Хүснэгт 6. Монгол улсад олгож буй цалингийн дундаж хэмжээ, салбараар, мян.төг

Салбар	2007	2008	2009	2010	2011
Улсын дундаж	173,0	274,2	300,5	341,5	424,2
Хөдөө аж ахуй	133,1	158,1	175,2	172,5	203,1
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	219,7	328,6	405,8	572,2	732,4
Боловсруулах аж үйлдвэр	160,2	268,0	271,9	326,2	402,4
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	165,7	240,9	297,3	337,5	411,3
Барилга	167,7	223,2	235,2	247,5	341,7
Бөөний болон жижиглэн худалдаа,	123,1	193,8	198,6	190,7	216,2
Боловсрол	174,3	213,0	203,5	193,7	208,6
Эрүүл мэнд, нийгмийн халамж	166,0	238,9	224,0	217,6	238,9
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	147,1	213,8	246,2	217,4	236,1

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011.

Хүснэгт 7-оос харвал цалингийн өсөлтийн улсын дундаж түвшин нь 24%-тай байгаа бөгөөд уул уурхай, барилгын салбарын цалингийн өсөлт хамгийн өндөр байна.

#### Хүснэгт 7. Монгол Улсад олгож буй цалингийн өсөлт (%), салбараар


Салбар	2007/2006	2008/2007	2009/2008	2010/2009	2011/2010
Улсын дундаж	35	58	10	14	24
Хөдөө аж ахуй	102	19	11	-2	18
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	50	50	23	41	28
Боловсруулах аж үйлдвэр	29	67	1	20	23
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	19	45	23	14	22
Барилга	26	33	5	5	38
Бөөний болон жижиглэн худалдаа,	44	57	2	-4	13
Боловсрол	41	22	-4	-5	8
Эрүүл мэнд, нийгмийн халамж	42	44	-6	-3	10
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	61	45	15	-12	9

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011-ийг ашиглан судлаач боловсруулав.

2011 оны Монгол ажилчдын авч буй цалингийн хэмжээг аж ахуйн нэгжийн хэлбэрээр нь авч үзвэл, гадаадтай хамтарсан хувийн компанид ажиллагсдын дундаж цалин хамгийн өндөр буюу 696,8 мянган төгрөг байхад, орон нутгийн өмчийн оролцоотой буюу хөдөө орон нутагт байгаа компаниудын цалин хамгийн бага 156,0 мянган төгрөг байна.

Харин сонирхолтой нь гадаадтай хамтарсан төрийн өмчийн байгууллагад ажиллагсдын цалин 2011 оны жилийн дундаж цалин нь 518,5 мянган төгрөг буюу улсын дунджаас өндөр үзүүлэлттэй гарсан байхад, 100% гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ажиллагсдын цалин 370,9 буюу улсын дунджаас бага гарсан байна (Зураг 1).

**Зураг 1. Цалингийн дундаж хэмжээ, өмчийн хэлбэрээр, мян. төгрөгөөр**



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011.

Эндээс үзэхэд гадаадтай хамтарсан хувийн компаниуд болон улсын өмчийн компаниудад уул уурхайн компаниуд тодорхой хувийг эзэлж байгаатай холбоотойгоор дундаж цалин нь өндөр байна.

Харин цэвэр гадаадын хөрөнгө оруулалттай компанид ажиллагсдын цалин нь улсын дунджаас доогуур гарч байгаа нь ихээхэн сонирхол татаж байна. Үүний шалтгааныг нь дараах байдлаар тайлбарлаж болно. Нэгдүгээрт, гадаадын хөрөнгө оруулалтыг салбараар нь судалж үзвэл нийт хөрөнгө оруулалтын 15,6% нь худалдаа нийтийн хоолны салбарт орсон<sup>10</sup> бөгөөд энэ салбар нь Монголын ГХО-ын жагсаалтанд хоёрдугаарт, уул уурхайн салбарын дараа орж байна. Гадаадын хөрөнгө оруулалт харьцангуй их орсон

худалдаа, нийтийн хоолны салбарын нэрлэсэн цалин болон цалингийн өсөлт нь улсын дунджаас болон бусад салбараас бага байгаа нь үүнд нөлөөлсөн байж болно. Хоёрдугаарт, гадаадын 100% хөрөнгө оруулалттай компаниуд нь ашиг олох үүднээс нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, орлогын албан татвараас тодорхой хэмжээгээр зайлсхийхийн тулд үндсэн цалинг багаар олгож, бусад татваргүй нэмэгдлийг олгодог байх гэж таамаглаж болох юм.

**3.2. Хүний хөгжлийн бодлого**

2008 онд Монгол Улсын Их Хурлаас Хөгжлийн стратегийг боловсруулсан бөгөөд 2020 он хүртэл өндөр хөгжилтэй орны хэмжээнд Монгол хүний хөгжлийг хүргэнэ гэсэн зорилт тавьсан. Одоогийн байдлаар

<sup>10</sup> 2011 оны байдлаар, Гадаадын хөрөнгө оруулалтын газар



Монгол Улсын хүний хөгжлийн индекс<sup>11</sup> нь 2011 онд нэмэгдэж дэлхийн 187 улсаас 110-т орсон, амьдралын чанараар 100 дугаарт орсон байна.<sup>12</sup> Зүүн хойд ази, номхон далайн бүс орнуудын индекс нь сүүлийн жилүүдэд нэмэгдсэн бөгөөд Монгол нь бүс нутгаасаа доогуур үзүүлэлттэй байна.<sup>13</sup> Нийт хүн амын 30% орчим нь ядуурлын хүрээнд амьдарч байна.<sup>14</sup>

Монгол улсын засгийн газраас уул уурхайн салбараас олсон орлогоо хүний хөгжилд зарцуулах бодлогын хүрээнд “эх орны хишиг олгох”, “эрдэнэсийн хувь хүртээх”, “хүний хөгжлийг нэмэгдүүлэх” ваучер<sup>15</sup>-ын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ бодлогод нийт хүн амын 95% хамрагдсан бөгөөд уул уурхайн салбараас олсон орлогоос ард түмэндээ “халамж үзүүлж” байгаа нь хүн амын орлогыг нэмэгдүүлэх нэг гол эх үүсвэр болж байна гэж үзэж болно.

Монгол Улсын Засгийн газраас 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө “Стратегийн болон томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1,5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчин болон санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүний дагуу Монгол Улсын Их Хурал Хүний хөгжил сангийн тухай хуулийг 2009 оны 11 дүгээр сард баталсан. “Хүний хөгжил сан” нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордоос олох орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг орлогоос хүн амд хишиг, хувь хүртээхээр

хуульчилсан. Энэ “хишиг, хувь” нь ард иргэдэд тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр, орон сууц худалдаж авсны төлбөр, бэлэн мөнгө, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөрийн хэлбэрээр олгогдохоор заасан байна.

Энэ бодлогоор “Хүний хөгжил сан”-гаас иргэдэд 2010 онд эхний ээлжинд 70 мянган, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэдэд 50 мянган төгрөг, нийт 120 мянган төгрөгийг бэлнээр, төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын хураамжинд нийт 10,9 тэрбум төгрөг олгохоор тусгасан. 2011 онд иргэн бүрт сар бүр 21 мянган төгрөг, нийт 252 мянган төгрөгийг олгон, оюутны сургалтын төлбөрт нийт 82,5 тэрбум төгрөг, төр хариуцах иргэдийн хураамж нийт 20,2 тэрбум төгрөг тус тус олгохоор тусгасан. 2012 онд 6 сар дуустал хугацаанд нийт 128000 мянган төгрөгийг олгох, түүнчлэн 55 ба түүнээс дээш настай эмэгтэй, 60 ба түүнээс дээш настай эрэгтэй ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрт 1 сая төгрөг тус тус олгохоор хуульчлан баталсан.

“Хүний хөгжил сан”-гийн тайлангаас үзвэл оюутнуудад 2 жилийн сургалтын төлбөр болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөх хэлбэрээр 1,0 сая төгрөгийг олгосон бөгөөд оюутнууд хишиг, хувиа бүрэн хүртсэн гэжээ. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 1,0 сая төгрөгийг 3 хувааж олгож байна. Мөн “Эрдэнэс Таван толгой” MGL хувьцаат компанийн 1072 ширхэг хүртэл хувьцааг эзэмших болсон бөгөөд өөрөөр хэлбэл иргэд хувьцаа хэлбэрээр хишиг, хувиа авч байна.

Манай улсаас явуулж буй энэ бодлогын хүрээнд Монголын иргэн бүрт тодорхой хэмжээний орлого нэмэгдэн орж байгаа бөгөөд үүний үр дүнгийн талаар янз бүрийн дүгнэлтүүд гарч байна. Манай улсын хувьд өндөр хөгжсөн улсуудын түүхийг дуурайж байгаа хэрэг болохоос биш Монголын эдийн засгийн онцлог байдлыг бодолцож үзэн өөрсдийн загварыг боловсруулаагүй юм.

11 Нэгдсэн үндэсний байгууллагаас хүний хөгжлийн индексээр хүний амьдарч буй түвшнийг тодорхойлон гаргаж байна. 1990 оноос эхлэн улс тус бүрийн дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох орлого зэрэг үзүүлэлтийг ашиглан боловсруулж байна. Мөн Олон улсын валютын сангаас нэг хүнд ногдох ДНБ, орлогын тэгш бус хуваарилалтын зэрэг, бага, ахлах дунд сургууль төгссөн байдал, бичиг үсэг тайлбарласан байдал, наслалт, эмнэлгийн үйлчилгээний түвшин зэргээр хүний хөгжлийн индексийг гаргаж байна.

12 UNDP, Human Development Report 2011

13 Амьдралын чанар нь 2011 онд 0,653 гарсан байгаа бөгөөд 187 улсаас 100 дугаарт орсон байна. Зүүн хойд ази, номхон далайн бүс орнуудын индекс нь 1980 онд 0,428 байснаас 2011 онд 0,671 болж дээшилсэн.

14 Монгол Улсын үндэсний статистикийн хороо, Монгол улсын статистикийн эмхэтгэл, 2011.

15 Ваучер (voucher)-ийн тухай “тухайлан хэн нэгэн хувь хүнд сургалт болон эмнэлгийн зэрэг тодорхой онцлог бүтээгдэхүүнийг хэрэглэж болох тусламжийн хэлбэрийн эрх”, мөн “хязгаарлагдмал тусгай бүтээгдэхүүн болон үйлчилгээг хувь хүн худалдаж авахыг хүлээн зөвшөөрч буй тусламжийн мөнгө юм” гэх зэрэг тодорхойлолтууд байдаг. Ваучер нь угаасаа Засгийн газраас ноогдлыг олгож байгаа ажил бөгөөд, ваучерийг авагч нь тодорхой эрх бүхий давхарга байдаг, орлогын түвшинг гол шалгуураа болгодог.

### 3.3. Ажил эрхлэлт

Эдийн засгийн өсөлтөнд ажил эрхлэлт чухал нөлөөтэй. Монгол Улсын эдийн засгийн идэвхитэй хүн ам 2011 онд 1124,7 мянга байсан ба ажиллах хүчний оролцооны

түвшин сүүлийн 5 жилд дунджаар 63,7 хувьтай байлаа.

Нийт ажиллагсдын тоо сүүлийн 5 жилд дунджаар 0,4%-аар өссөн ба хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тоо 2007 оноос 13,6 мянгаар өсчээ.

#### Хүснэгт 8. Ажил эрхлэлтийн зарим гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011
Хөдөлмөрийн насны хүн ам /мян/	1 642,2	1 688,7	1 853,5	1 863,4	1 798,39
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо /мян/	1 054,0	1 071,5	1 137,9	1 147,1	1 124,71
Үүнээс:					
Ажиллагчдын тоо /мян/	1 024,1	1 041,7	1 006,29	1 033,7	1 037,68
Үүнээс: Уул уурхай, олборлох салбарт ажиллагсдын тоо /мян/	44,1	46,5	34,8	34,1	45,1
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	64,18	63,45	66,76	61,60	62,50
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	97,16	61,69	88,43	90,10	92,30
Ажилгүйдлийн түвшин, %	-	-	11,57	9,89	7,74
Ажилгүйдлийн түвшин, % (2009 оноос өмнөх аргачлалаар) <sup>1</sup>	2,84*	2,78*	3,35	3,34	5,09

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2008, 2011.

Уул уурхайн салбарт ажиллагсдыг авч үзвэл, тооны хувьд дунджаар 2,6%-аар өссөн ба тус салбарт ажиллагсдын тоо нийт хөдөлмөр эрхлэгчдийн 4,3%-ийг эзэлж байна.

8700 ажлын байрыг шинээр бий болгосон байна.<sup>16</sup> 2001 оны байдлаар 45,1 мянган хүн тус салбарт ажиллаж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт өсч, олон уурхай шинээр ашиглалтад орсноор тус салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл жилээс жилд нэмэгдсээр байна. Тухайлбал 2009 онд 14 уурхай, 2010 онд 12 уурхай, 2011 онд 19 уурхай үйл ажиллагаагаа эхлэснээр нийтдээ

Ашигт малтмалын хайгуулын ажлуудын үр дүнд уул уурхайн ашиглалт, олборлолтын шинэ шинэ төслүүд цаашид өмнийн говийн аймгуудад хэргэжижээр төлөвлөгдөж байгаа билээ. “Sustainability East Asia” компаний судалгаагаар шинээр хэргэжиж эхлэх уул уурхайн төслүүд нь ирэх 5 жилд 11000 гаруй ажлын байрыг шинээр бий болгоно хэмээн тооцоолсон байна.

#### Хүснэгт 9. Уул уурхайн салбарт шинээр бий болох ажлын байрны таамаглал

Ордын нэр	Ашигт малтмал	Ашиглах хугацаа	Олборлолтын хэмжээ, (мян. тонн/жилд)	Шинээр бий болгох ажлын байр	Эхлэх хугацаа
<b>Өмнөговь</b>					
Таван толгой	Нүүрс	200+	15000	1500	2012
Ухаа худаг	Нүүрс	100	10000	1000	2009
Баруун Наран	Нүүрс	20	6000	500	2012
Цагаан толгой	Нүүрс	20	2000	150	2015
Нарийн сухайт	Нүүрс	40	2000	150	2003
Овоот толгой	Нүүрс	50	5000	400	2008
Оюу толгой	Зэс	50	2000	4000	2012

<sup>16</sup> ҮСХ-ны 2009 оноос өмнө ашиглаж байсан аргачлалын дагуу. Ажилгүйдлийн түвшинг 2009 оноос хойш өөр аргачлалаар тооцох болсон ба ажилгүйдлийн түвшин сүүлийн гурван жилд дунджаар 9,7%-тай байна.

**Хүснэгт 9. Уул уурхайн салбарт шинээр бий болох ажлын байрны таамаглал**

Ордын нэр	Ашигт малтмал	Ашиглах хугацаа	Олборлолтын хэмжээ, (мян. тонн/жилд)	Шинээр бий болгох ажлын байр	Эхлэх хугацаа
<b>Говь-Сүмбэр</b>					
Сүмбэр	Нүүрс	50	5000	400	2015
Шивээ овоо	Нүүрс	200+	14000	600	2015
<b>Дорноговь</b>					
Цагаан суврага	Зэс	30	0,5-1,3 сая тонн зэс	1500	2015
<b>Дундговь</b>					
Төмөртэй	Төмөр	-	4,6	-	-
Хараат	Төмөр, цайр	-	15,0-20,0	107	-
Эрээн	Төмөр	-	1,0	1000	-
Үнст худаг	Нүүрс	-	98,0	-	-

Эх үүсвэр: Говийн бүсийн техник мэргэжлийн үр чадвар, ажиллах хүч, сургалтын судалгаа, эцсийн тайлан, 2010.10.29. Sustainability East Asia ХХК

Уул уурхайн салбарт ажлын байр нэмэгдэж байгаа, цаашид нэмэгдэх хандлагатай байгаа нь үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн шилжилтийг тухайлбал ажиллах хүчний шилжилтийг нэмэгдүүлж, энэ салбарт ажиллагсдын тоо, цалинг нэмэгдүүлэх нөхцөл болж байна.

**4. Дүгнэлт**

Дэлхийн зах зээлийн байгалийн нөөцийн эрэлтийн өсөлтөөс шалтгаалан сүүлийн жилүүдэд Монголын уул уурхайн салбарын өсөлт нь хурдацтай явагдаж байгаа бөгөөд ДНБ-д эзлэх хувь нь сүүлийн 5 жилээр харвал жил бүр 20%-с дээш хувиар өссөн байна. Харин боловсруулах үйлдвэрлэл, барилга, худалдаа, тээвэр, мэдээлэл холбоо, үл хөдлөх хөрөнгө, төрийн удирдлага, батлан хамгаалах салбарын өсөлт сүүлийн жилүүдэд тогтворгүй байна. Энд хамгийн сэтгэл эмзэглүүлж байгаа асуудал нь улс орны хөгжилд хамгийн чухал нөлөөтэй ХАА, цахилгаан, усан хангамж, санхүү даатгал, мэргэжлийн ШУ боловсрол, эрүүл мэнд зэрэг салбаруудын өсөлт буурсан байсан.

Нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн үйлдвэрлэл огцом нэмэгдэж, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан байна.

Мөн нүүрс, газрын тос гэсэн бүтээгдэхүүний экспорт хамгийн их нэмэгдсэн бөгөөд уул уурхайн салбарт орж ирсэн ГХО хэмжээ жил бүр нэмэгдэж 2011 онд 316,4% өссөн байна. Уул уурхайн салбарыг энэ эрчимтэй хөгжил нь үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг бусад салбараас татаж авч байна гэж хэлж болно. Тухайлбал, өндөр боловсролтой болон илүү чадварлаг, мэргэшсэн боловсон хүчин уул уурхайн салбар луу шилжих хөдөлгөөн хүчтэй явагдаж бусад салбар нь боловсон хүчний дутагдалд орон үйлдвэрлэлийн бүтээмж буурах хандлагатай байна.

Баялгийн олборлолтоос үүдэлтэй манай эдийн засгийн хөгжлийн үр дүнд уул уурхайн салбарын гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, орлого өсч байгаагаас уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хөлс нэмэгдэж, энэ нь бусад салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэж болно. Уул уурхайн салбар болон барилгын салбарт ажиллагсдын цалин хамгийн ихээр өссөн харин боловсрол, эрүүл мэнд, үйлчилгээний салбарт ажиллагсдын цалингийн өсөлт хамгийн бага байгаа нь үнийг баталж байна. Уул уурхайгаас орж ирэх орлого нэмэгдсэнээр эдийн засаг дахь цалин болон үнийн түвшин өсч байгаа бөгөөд энэ нь манай улсын өрсөлдөх чадварыг сулруулж

байна. Мөн уул уурхайн салбар эдийн засагт байгаа капитал болон хөдөлмөрийн хүчин зүйлсийг татсанаар нэг салбарын хэт давамгайлал бий болж Голланд өвчний эрсдлийг нэмэгдүүлж байна гэж хэлж болно. Бидний баялаг болох байгалийн баялаг эдийн засаг, нийгэмд дандаа сайн сайхныг дагуулдаггүй, уул уурхайн бүтээгдхүүний экспортод тулгуурласан эдийн засаг урт хугацаанд өсөлтийг үзүүлж чаддаггүй нь олон улсын туршлагаар батлагдсан билээ.

Байгалийн баялгийн салбарын өсөлтийн сөрөг үр дагаварт эдийн засгийн хүчин зүйлсээс гадна улс төрийн шийдлүүд нөлөөлдөг. Юуны түрүүнд байгалийн баялгаас орж ирэх орлогын “буруу удирдлага” нь нөхцөл байдлыг улам даамжруулдаг гэж үздэг. Мөн Монгол улс нь баялгийн санг зөв зохистой, оновчтой зарцуулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хүний хөгжлийг нэмэгдүүлэхийн тулд бусад улсын туршлагыг судалж хэрэгжүүлэх нь зөв боловч, өөрийн орны онцлогт тохирсон оновчтой стратегийг боловсруулах нь чухал юм. Хүний хөгжлийг дэмжих бодлого нь уул уурхайн салбараас олох орлогыг бүх иргэдийг хамруулж хуваарилах давуу тал байгаа боловч ард иргэдийг бэлэнчлэх сэтгэлгээтэй болгох сул талтай нь ойлгомжтой юм. Тиймээс энэ орлогын зөв удирдах “судалгаанд тулгуурласан”, “оновчтой”, “монголд менежмент”-ийг бий болгох шаардлагатай байна. Тухайлбал, сул хөгжсөн дэд бүтэц, хүнд болон хөнгөн аж үйлдвэрийн салбарууд, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх замаар эдийн засгийн бусад салбарт ажлын байрыг бий болгож, тэдгээр салбарын ДНБ-д эзлэх хувийг өсгөхөд “баялагийн санг ашиглах” нь зүйтэй гэж үзэж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Монгол хэл дээр

Ким Хонг Жин, С.Бурмаа, 2010, “Монголын экспорт, импортын тогтолцооны шинжилгээ ба гадаад худалдааны бодлогыг шинэчлэлтийн хөтөлбөр”

Монгол Улсын статистикийн хороо, 2011, “Монгол Улсын статистикийн эмхэтгэл”  
МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, 2011, Гадаадын хөрөнгө оруулалтын газар, 2011 оны статистик  
Эрдэс Баялаг Эрчим Хүчний Яамны Хэвлэл Мэдээллийн Алба, 2010. “Монгол Улсын газрын тосны салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт”

### Англи хэл дээр

ADB, 1992. *Mongolia : A Centrally Planned Economy in Transition*

Alicia Campi, 2012. “Mongolia’s Quest to Balance Human Development in its Booming Mineral-Based Economy”, Brookings Northeast Asia Commentary, Number 56, Brookings, January 2012

Bernt Bernander, Nathalie Bouchй and Lkamsuren Nyamtseren, 2005. Forging Links between Poverty and Policy: An Evaluation of the Project (Poverty Research and Employment Facilitation for Policy Development), Government of Mongolia/ UN Development Programme, September 2005:23.

Black, S. W, 2001. “Obstacles to Faster Growth in Transition Economies: The Mongolian Case,” IMF Working Paper, March.

UNDP, 2009. Human Development Fund law approved, Mongoliana, UB-Mongolia, 20 November 2009

UNDP, 2012. Tyondon-researcher, Social welfare distribution & poverty, Wednesday, January 11, 2012, Human Development Report 2011

World Economic Forum, Global Competitiveness index, 2012-2013

### Солонгос хэл дээр

조명철, 김지연, GTI의추진동향과국제협력방안, 대외경제정책연구원, 2010.10:72;  
몽골석탄매장량 1,623억톤, 몽골교민신문, 2011.04.17

심의섭, 국제자원정세와몽·한자원개발협력, 2009

### Бусад мэдээлэл

<http://economy.news.mn/content/111181.shtml/2012.12/>